

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны үйл ажиллагааг Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ), Байгууллагын чадамжийн үнэлгээ, Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ гэсэн 3 чиглэлээр хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараа оны гүйцэтгэлийн төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх, тайлагналтыг сайжруулах

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.3, 2.4-д заасан аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлж дүгнэсэн.

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэхүү журмын 2.5-д заасан аргачлалын дагуу арга хэмжээний үнэлгээгээр 3 ангилалд шилжүүлэн тооцсон.

НЭГ. БОДЛОГЫН ҮР ДҮН

**1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн
бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн**

Хамаарах заалт байхгүй.

1.2. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хамаарах заалт байхгүй.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДҮН (ҮНЭЛГЭЭ)

2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 51 арга хэмжээ тусгагдсан байна.

2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийгдсэн дүнгээр **99.6%** буюу **"бүрэн хангалттай"** үнэлэгдлээ.

Журмын 2.5-д заасан аргачлалын дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг 4 зорилтоор үнэлсэн байдал:

Зорилт	Арга хэмжээний	Хэрэгжилт	Дундаж хувь
--------	-------------------	-----------	----------------

	тоо	85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
Нэг.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	7	7	-	-	98.9%
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	18	18	-	-	99.6%
Гурав. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	19	19	-	-	100%
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ	7	7	-	-	100%
Нийт	51	51	-	-	99.6%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2025 онд тус төвийн шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажилд хамааралтай Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын болон Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын тушаал нийт 14 шийдвэрийг 100% хэрэгжүүлж ажилласан байна. *(дэлгэрэнгүй тайлан хавсаргае)*

Хууль,тогтоомж, тогтоол шийдвэр	Тоо	Хэрэгжилт			Хэрэгжилтийн дундаж хувь
		85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
Монгол Улсын Засгийн газрын тогтоол	4	4			100
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр	1	1			100
БОУАӨСайд, ЦУОШГ-ын даргын тушаал	9	9			100
Нийт	14	14	-	-	100

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн С/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” стандарт (MNS 7068:2025)-ын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны стандартыг хангаж ажиллаж байна.

Бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг дахин боловсруулж төвийн даргын 2025 оны А/37 тушаалаар баталсан.

Батлагдсан АТТ-ын албан тушаалд тавих тусгай шаардлагын боловсрол, мэргэжил, ажлын туршлага, ур чадвар, манлайлал зэргийг харгалзан албан тушаалд томилгоо

хийгдсэн. 2025 оны 08 дугаар сард хийгдсэн бүтэц, орон тооны цомхотголоор 9 орон тоо хасагдсан учир албан хаагчид албан тушаал хавсран гүйцэтгэлэхэд 3 албан хаагч албан тушаал ахисан.

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн “2025-2028 оны Албан хаагчдын ажлалх нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” батлагдаж 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 97.8 хувь буюу **“бүрэн хангалттай”** үнэлэгдлээ.

2025 оны Төвийн албан хаагчдын ажлалх нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг журмын 2.5-д заасан аргачлалын дагуу үнэлсэнг хувиар илэрхийлбэл:

Зорилт	Арга хэмжээний тоо	Дундаж хувь
Нэг. Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх	10	95.6%
Хоёр. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах	19	100%
Нийт	29	97.8%

3.3. Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ

2025 оны 3 дугаар сард Удирдлагын академаас зохион байгуулсан “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сургалт, Монголын эмэгтэйчүүдийн академийн академич, доктор, дэд профессор Ж.Оюун “Монгол үндэстэн-Монгол хүний бахархал”, “Хүний мэдвэл зохихуй хууль”, “Ёс зүйтэй ирээдүй хойч” зэрэг сэдвээр цуврал 12 цагийн сургалт зохион байгуулсан.

2025 оны 5 дугаар сард төвийн Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.4, 8.2.1 дэх заалтыг зөрчсөн үйлдэл гаргасан тухай гомдол ирсэн. Гомдолыг судалж дүгнэлт гарган төвийн захиргаанд танилцуулсан. Уг дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан хариуцлагыг хүлээлгэсэн.

3.4. Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт

Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газраас 2024 оны төсвийн жилийн санхүүгийн тайланг түүврийн аргаар шалгасан. Санхүүгийн балансын урамшуулал олгох зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж 2025 онд санхүүгийн урамшуулал олгоогүй.

3.5. Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт

Төвийн ХШҮ-ний багаас 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ бүрт суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжигдэхүйц байдлаар

тусгах, тайланд хүрсэн түвшинг, хүрэх түвшинтэй уялдуулан үнэлэх тухай зөвлөмжийг 2025 оны жилийн эцсийн тайланд хэрэгжүүлсэн.

2025 онд төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах, цаашид стратегийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байхыг зөвлөмж өгсөн.

2025 оны 07 дугаар сарын 05-06 ны өдрүүдэд ЦУОШГ-аас Дотоод аудит, хяналт шалгалт хийгдэж өгсөн зөвлөмжийг дагуу дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

1. Албан хаагчдын хувийн хэрэг, цалин хөлсний холбогдох мэдээллийг шинэчилж, баримтын давхардал, дутууг арилгав.
2. Төсвийн гүйцэтгэл, нэмэлт тайлбар, орлого зарлагын баримтуудыг аудитын шаардлагын дагуу нарийвчилсан тайлбартай болгосон.
3. Архивын мэдээлэл, цахим бүртгэл, баримтын хадгалалтад зөвлөмжийн дагуу сайжруулалт хийсэн.

Дөрөв. ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

4.1. Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн


Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг:

1. Ажиллах орчин, багаж төхөөрөмжийг сайжруулах
2. ТА-ны меррит зарчимыг хадгалах, хувь хүний хөгжлийг дэмжих
3. Ажлын ачаалал, ажил - амьдралын тэнцвэрт байдлыг хангах

3 индексийг тодорхойлох 7 асуулгаар санал авахад нийт албан хаагчдын 96.9% нь хамрагдсан.

Судалгааны үр дүнгээр ажиллах орчин, багаж төхөөрөмжийг сайжруулах, ТА-ны меррит зарчимыг хадгалах, хувь хүний хөгжлийг дэмжих индексүүд 80%-тай хангалттай үнэлгээтэй гарсан байна.

Ажилтны ажлын ачаалал, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангах индекс 75%-тай байгаа нь хангалттай үнэлгээ хэдий ч төвийн удирдлага цаашид анхаарлаа хандуулах шаардлагатай байна.



Дүгнэлт:

1. Ажлын байрны орчин нөхцөл, багаж төхөөрөмжийг сайжруулах индекс 80%-д хүрсэн агаарын чанарын харуулын ажлын байр, цаг уурын 1 өртөө, 2 харуул, усны 2 харуулын ажиглалтын талбайг орон нутгийн 20.4 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар шинээр хийсэн, улсын төсвийн 35.3 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар усны харуулын


ажлын байр шинээр баригдсантай холбоотой үнэлгээ ахисан. 2024 оны судалгааны дүнтэй харьцуулахад 10%-иар ахисан.

2. ТА-ны меррит зарчмыг хадгалах, хувь хүний хөгжлийг дэмжих индекс өмнөх оноос 15%-иар ахиж 80%-д хүрсэн нь ажилтнуудыг гадаад, дотоодын сургалтад хамруулсан, 3 албан хаагч албан тушаал ахисан, хувь хүний хөгжлийг дэмжиж 2 албан хаагчийг ХААИС-д сурах боломжоор хангасан нь тодорхой хэмжээнд ахисан гэж үзэж байна.

3. Ажлын ачаалал, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангах үнэлгээ 75% болж өмнөх оноос 7%-иар буурсан шалтгаан нь 2025 оны 08 дугаар сард хийгдсэн бүтэц, орон тооны цомхотголоор 9 орон тоо хасагдсан учир албан хаагчид албан тушаал хавсран гүйцэтгэж ачаалал нь нэмэгдэж илүү цагаар ажиллаж байгай холбоотой. Илүү цагаар ажиллаж байгаа нь ажил-амьдралын тэнцвэр алдагдуулсан гэж дүгнэлээ.

4. Цаашид албан тушаалын тодорхойлолтын шаардлага, мэргэжлийн чиглэлд нийцүүлж ажил хавсран гүйцэтгүүлбэл ажлын ачаалал багасах, гүйцэтгэл сайжрах боломжтой гэж дүгнэж байна.

Судалгаанд оролцогчдоос 30 санал ирж багцлахад ажлын орчин сайжруулах 33.3%, багаж төхөөрөмжийг сайжруулахад 29.1%, харилцаа хандлага ёс зүй 20.8%, сургалт, хүний хөгжил чиглэлээр 16.7% -ийн санал ирсэн.



Дээрх саналуудыг хэрэгжүүлэхээр дараах ажлуудыг төлөвлөсөн байна. Үүнд:


1. Ус судлалын 2 харуул дээр дотоод нөөц бололцоогоо ашиглаж ажлын байртай болгох
2. Усны автомат багажтай болох, БОШЛ-ийн багаж төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх
3. Ажилтаны ур чадварыг сайжруулах
4. Ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх

4.2. Байгууллагын шударга байдлын үнэлгээ

Байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээг тодорхойлох индексийг 3 үзүүлэлтийн 5 асуулгаар авахад 31 албан хаагч 96.9%-тай хамрагдсан.

Байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээг албан хаагчдаа эрх тэгш хандаж байгаа эсэх, үйл ажиллагаа ил тод шударга, ажлын үзүүлэлт бүрийг ялгаварлалгүй зөв үнэлж, хэн нэгэн албан хаагчдад давуу эрх мэдэл олгох үйлдэл гарч байгаа эсэх гэсэн 2 индексээр 73.3%-тай үнэлсэн.

Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлс таны ажлын гүйцэтгэлд нийцтэй байгаа эсэх 76.7%-тай үнэлсэн.



Дүгнэлт:

1. Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлс таны ажлын гүйцэтгэлд нийцтэй байгаа эсэх дээр 76.7%-тай үнэлсэн нь аймгаас орон нутгийн нэмэгдэл 40% олгож байгаа, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг улирал бүр олгож байгаагаар холбоотой ахиу үнэлэгдсэн байна.

2. Төвийн захиргааны зүгээс байгууллагын үйл ажиллагаагны нээлттэй, ил тод байдлыг хангаж дотоодын групп чат, фэйж хуудсаар олон төрлийн мэдээлэл байнга тавьж танилцах үүрэг өгдөг ч албан хаагчид уншиж танилцах идэвхи сул байгаагаар холбоотой 2 индекс 73.3% тай үнэлэгдсэн

Дотоод шударга байдлын үнэлгээ авахад 5 ажилтнаас санал ирсэн нь нийт оролцогчийн 16.1% -ийг эзэлж байна. Үнэлгээ бага байгаа үзүүлэлтээр дэлгэрэнгүй санал асуулга авч цаашид хэрэгжүүлж ажиллах

4.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)

1. ЗГ-ын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу shilen.gov.mn цахим мэдээллийн сайтад байршуулсан байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт 4-р улиралд 100% -д хүрсэн.


2. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2025 оны III улирлын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгасан дүнгээр 135 мэдээг хугацаанд нь бүрэн байршуулж 100%-иар дүгнэгдсэн. Шилэн дансны цахим ситемд 2025 онд нийт 171 мэдээллийг байршуулахаас 11 дүгээр сарын 28-ны байдлаар 139 мэдээг 100% оруулж үнэн зөв тайлагнасан.

4.4. Хэрэглэгчийн үнэлгээний дүн

Хэрэглэгчийн үнэлгээг 2025 оны 9 дүгээр сарын 30-нд Шарын гол сумын төвд, 10 дугаар сарын 29-нд “Номин агуулах худалдаа”-ны төвд хийсэн нээлттэй өдөрлөгийн үеэр иргэдээс авсан санал асуулгын дүнг нэгтгэсэн.

2025-2026 оны өвлийн улирлын прогноз танилцуулах, darkhan-uul.weather.gov.mn сайтаас үйлчилгээ авах, өнөдөр настангуудын гар утсанд Ус, цаг уурын мэдээлэл түгээдэг пэйж хуудсыг дагагчаар оруулж хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 59% нь цаг уурын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, 52% нь албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага сайн, 87% мэдээлэл хүртээмжтэй, хангалттай, 22% 7 хоногийн дотор хүсэлтийнхээ хариуг авсан, 78% хандаж байгаагүй гэсэн дүн гарсан.



Өдөрлөгийн үеэр авсан санал асуулгаар иргэдийн 91.5% нь уур амьсгалын өөрчлөлт ажил, амьдралд мэдрэгддэг тухай хариулсан байна.

№	Асуулга		Хувь
1	Уур амьсгалын өөрчлөлт таны амьдралд мэдрэгдэж байгаа эсэх	Тийм	91.5
		Үгүй	17.0
2	Цаг агаарын мэдээний ашиглалт	Өдөр бүр	71.2
		Хэрэгцээ гарсан үед	27.8
		Огт ашигладаггүй	1.1
3	Мэдээний таарц, үнэлгээ	Маш сайн	77.4
		Заримдаа	20.5
		Таардаггүй	2.1
4	Түлхүү ашигладаг мэдээний төрөл	1 хоногийн урьдчилсан мэдээ	20.9
		5-7 хоногийн урьдчилсан мэдээ	67.8
		Сар, улирлын урьдчилсан мэдээ	9.6

5	Та цаг агаарын мэдээллийг хүлээн авдаг эх үүсвэрүүд	Цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах мэдээ	8.1
		ХААЦУ-ын мэдээ	4.8
		Агаарын бохирдол, ус, хөрсний чанар	1.6
		Телевиз	37.3
		darkhan-uul.weather.gov.mn сайт	11.5
		Фэйсбүүк	18.1
		Гар утасны апплейкшн	40.0
		Утас 9937-9420, 7037-4161	9.3

Асуулгад оролцогч иргэдийн 71.2% нь цаг агаарын мэдээг өдөр бүр ашигладаг, 45.8-54.5% мэдээний таарц маш сайн, сайн, 67.8% нь 5-7 хоногийн урьдчилсан мэдээ ашигладаг, 37.3-40.0% нь мэдээллийг телевиз болон гар утасны апплейкшнээс авдаг тухай хариулсан.

Цаашид байгууллагын үйл ажиллагааг сурталчилж ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, ТАХ-ийн стандартыг мөрдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах, ТАХ-ын ёс зүйн тухай чиглэлээр төвийн Ёс зүйн дэд хороотой хамтарч сургалт, соён гэгээрүүлэх ажил хийнэ.

ТАВ. ДҮГНЭЛТ

1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 99.6%-тай дүгнэгдсэн.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгасан, хүрсэн түвшинг, хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнах тухай 2024 оны зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

3. 2025 оны "Төвийн албан хаагчдын ажллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлт 97.8%-иар дүгнэгдсэн, Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан боловсон хүчний тоо, гадаад, дотоод хамтын ажиллагааны сургалтууд нэмэгдсэн нь байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилт биелэгдсэн байна.

4. Тайланд зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийг тодорхой тайлагнаагүй.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

1. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхой тайлагнаж холбогдох нотлох баримтыг хавсаргах

2. Тус төвийн 2025-2028 оны стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

3. Бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа зөвлөмжийн биелэлтийг хангах

4. Төлөвлөлт хийхдээ сургалтын хэрэгцээг тодорхойлох, оролцогчдын тоог зөв тогтоож оролцоог бүрэн хангуулах, сургалтын ач холбогдол, чанар, үр дүнг сайжруулах

5. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний 3.11.4.1.2-д тусгасан арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй 70% хэрэгжилттэй байгаа тул цаашид улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдүүлэх зэрэг зөвлөмж, чиглэлийг өгч байна.

ТАНИЛЦСАН:

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА



С.АЛТАНДОЛГИОН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:


ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН
АХЛАГЧ



А.БАТГЭРЭЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ГИШҮҮН



Т.НЭРГҮЙ

Ө.АЛТАНЗУЛ